

Төсөл

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хангамж, бараа материалын зардал”, “Нормативт зардал”, “Хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардал”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Үйлчилгээнд хамрагдах иргэний холбогдох бичиг баримтын загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт / нарт үүрэг болгосугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

САНГИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

Ч.ХҮРЭЛБААТАР

# ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг тооцоход энэхүү журмыг баримтлана.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээ” гэж түр хамгаалах байрны үйлчлүүлэгчийн тооноос хамааруулан нийт хэмжээ нь өөрчлөгдөх зардлыг;

1.2.2. “санхүүжих дундаж хүний тоо” гэж түр хамгаалах байраар үйлчлүүлэхэд ногдох хувьсах зардлын хэмжээг тооцоход ашиглан батлагдсан журмын дагуу төсвийн жилд харгалзуулан тооцсон хүний тоог;

1.2.3. “хүн өдөр” гэж тодорхой хугацааны нийт өдөрт хамрагдах хүний тооны үржвэрийг;

1.3. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нийт санхүүжилт нь түр хамгаалах байрны ажилтнуудын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг төлөх зардал, түр хамгаалах байраар үйлчлүүлж буй нэг хүнд ногдох хувьсах зардлаас бүрдэнэ.

1.4. Түр хамгаалах байраар үйлчлүүлж буй нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээг энэ журмын хоёр дахь хэсэгт заасны дагуу тооцож, хувьсах зардлын санхүүжилтийн нийт хэмжээг санхүүжих дундаж хүний тоо, хүн өдрийг үндэслэн тооцож гаргана.

## **Хоёр. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээг тооцох**

2.1. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал нь Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн дараах ангиллаас бүрдэнэ:

2.1.1. цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал;

2.1.2. ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл;

2.1.3. хангамж, бараа материалын зардал;

2.1.4. нормативт зардал;

2.1.5. хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардал

2.1.6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 “аюулгүй байдлын хамгаалалт”, 33.1.3 “сэтгэл зүйн үйлчилгээ”, 33.1.4 “нийгмийн халамжийн үйлчилгээ”, 33.1.5 “хүүхэд хамгааллын үйлчилгээ”, 33.1.7 “холбон зуучлах үйлчилгээ” зэрэг хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардал;

2.2. Журмын 2.1.1, 2.1.2-т заасан зардлыг дараах байдлаар тооцно.

2.2.1. Төрийн байгууллагын дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа түр хамгаалах байранд ажиллах ажилтнуудын цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын хэмжээг төрийн үйлчилгээний адилтгах албан тушаалын албан хаагчийн цалин хөлсний жишгийг үндэслэн тогтоож, холбогдох нэмэгдлийг олгож, түүнд ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг тооцно.

2.2.2. Гэр бүлийн тухай хуулийн 13.1.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн бус байгууллагад ажиллах ажилтнуудын цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын хэмжээг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулж, хамтын гэрээний хүрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

2.3. Журмын 2.1.3 “Хангамж, бараа материалын зардал”; 2.1.4 “Нормативт зардал”; 2.1.5.“Хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардал”; “Үйлчилгээнд хамрагдах иргэний холбогдох бичиг баримтын загвар”-г хоёрдугаар хавсралтаар батална.

2.4. Журмын 2.1.5-д заасан хохирогчид үзүүлэх “Нийгмийн халамжийн үйлчилгээ”-г Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.4 дэх заалт, “Хүүхэд хамгааллын үйлчилгээ”-г Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5.3 дахь хэсэгт зааснаар тус тус үзүүлнэ.

2.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь хэсгийг үндэслэн Засаг даргын өргөн мэдүүлсэн хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг орон нутгийн төсөвт тусган баталж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ.

2.6. Хаягийн бүртгэлгүй, зөрчилтэй иргэн түр хамгаалах байраар үйлчлүүлсэн тохиолдолд тухайн иргэний хамгийн сүүлд оршин сууж байсан орон нутаг нь бичиг баримтжуулах зардлыг хариуцна.

2.7. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан хоёр жилд нэг удаа шинэчлэн тогтоож болно.

ТӨСӨЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
 Сангийн сайдын хамтарсан  
 2019 оны...дугаар сарын ....-ны өдрийн  
 .....дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ БАЙГАА  
 ИРГЭНИЙ ХОНОГТ ХЭРЭГЛЭХ ХАНГАМЖ,  
 БАРАА МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ**

№	Бараа материалын нэр	Эдэлгээний хугацаа	Үнийн дүн
<b>Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс</b>			
1.1	Гарын саван	1 хоногт	200
1.2	Эдийн саван	1 хоногт	200
1.3	Шүдний оо	1 хоногт	200
1.4	Шүдний сойз	1 хоногт	100
1.5	Сам	1 хоногт	100
1.6	Шампунь	1 хоногт	300
1.7	Гар нүүрийн алчуур	1 хоногт	200
1.8	Ариун цэврийн хэрэгсэл /дамск, памперс/	1 хоногт	2000
1.9	Гар нүүрийн тос	1 хоногт	300
1.10	Ариун цэврийн цаас	1 хоногт	500
1.11	Хог хаягдал, хортон мэрэгчийн устгал	1 хоногт	300
<b>Дэд дүн</b>			<b>4400</b>
1.12	Бичиг хэрэг	1 хоногт	1500
1.13	Харилцаа холбоо	1 хоногт	1500
1.14	Тээвэр шатахуун	1 хоногт	3000
<b>Дэд дүн</b>			<b>6000</b>
<b>НИЙТ ДҮН</b>			<b>10400</b>

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
Сангийн сайдын хамтарсан  
2019 оны ...дугаар сарын ....-ны өдрийн  
.....дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ БАЙГАА ИРГЭНИЙ ХОНОГТ  
ХЭРЭГЛЭХ ХООЛНЫ НОРМ, ИЛЧЛЭГИЙН ХЭМЖЭЭ, ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ**

**Шимт бодисууд (гр)**

Д/ д	Хүнсний бүтээгдэхүүний нэр	Хоногт хэрэглэх хэмжээ (гр эсвэл мл)	Хоногт хэрэглэх хүнсний өртөг төгрөгөөр		Уураг			Тос			Илчлэг (ккал)	
			үнэ	кг-ын	Нийт	Үүнээс		Нийт	Үүнээс			Нүүрс ус
						Амьтны	Ургамлын		Амьтны	Ургамлын		
1	Малын мах /үхэр/	120	1303	10862	19	19		12	12		180	
2	Сүү (үнээний сүү, 3.2% тос)	160	304	1900	5	5		5	5	8	95	
3	Гурил /алтан тариа I/	100	106	1056	13		13	1		1	74	357
4	Гурилан бүтээгдэхүүн /атар талх/	180	224	1246	14		14	2		2	125	575
5	Төрөл бүрийн будаа /цагаан будаа/	50	170	3403	4		4	0		0	31	140
6	Төмс	120	98	818	2		2	0		0	24	108
7	Хүнсний ногоо /лууван/	260	377	1449	3		3	0		0	18	85
8	Буурцагт ургамал	40	174	4350	8		8	1		1	20	119
9	Өндөг	20	326	326	3	3	0	2		2	0	32
10	Ургамлын тос	23	79	3453				23		23		207
11	Сахар, чихрийн зүйл /элсэн чихэр/	33	87	2642							33	128
<b>Бүгд</b>		<b>1106</b>	<b>3248</b>	<b>31505</b>	<b>90</b>	<b>45</b>	<b>45</b>	<b>67</b>	<b>37</b>	<b>30</b>	<b>360</b>	<b>2400</b>

Үндсэн шимт бодисын илчлэг	360			600			1440	
Үндсэн шимт бодисын илчлэгийн хувь	15%			25%			60%	

ТӨСӨГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
 Сангийн сайдын хамтарсан 2019 оны  
 ...дугаар сарын ....-ны өдрийн  
 .....дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ БАЙГАА  
 ИРГЭНИЙ ХОНОГТ ХЭРЭГЛЭХ НОРМАТИВ ДУНДАЖ ЗАРДАЛ**

№	Норматив зардал			
	Зардлын ангилал	Хугацаа хоногоор	Үнийн дүн төгрөгөөр	Тайлбар
2.1	Хоолны зардал	1 хоногт	9496	<ul style="list-style-type: none"> <li>• Хоногт өдөр, оройн хоол, 2 удаагийн хөнгөн цай,</li> <li>• Нэг удаагийн цайны зардлыг 1500 төгрөгөөр тооцов.</li> <li>• Хоногийн хоолны нэг удаагийн зардлыг (2780 төгрөгөөр) тооцов.</li> </ul>
2.2	Эмийн зардал	1 хоногт	1500	<ul style="list-style-type: none"> <li>• Өвчин намдаах эм,</li> <li>• Халуун бууруулах эм,</li> <li>• Ханиад томууны эсрэг эм,</li> <li>• Гэдэсний өвчин намдаах эм.</li> </ul>
<b>Дэд дүн</b>			<b>10996</b>	



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
Сангийн сайдын хамтарсан  
2019 оны...дугаар сарын ....-ны өдрийн  
.....дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

### ХОХИРОГЧДОД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

3	Үйлчилгээний төрөл	Хугацаа	Үнийн дүн	Тайлбар
3.1	Аюулгүй байдлын хамгаалалт /33.1.1/	1 хоногт	3500	<ul style="list-style-type: none"> <li>Байр ашиглалтын зардал /дулаан, цахилгаан, цэвэр ус, бохир ус/</li> <li>Хамгаалалт /камер, харуул хамгаалалт, нүүлгэн шилжүүлэлт/</li> </ul>
3.2	Эмнэлгийн тусламж үйлчилгээ /33.1.2/	1 хоногт	3500	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн 2 дахь шатны үзлэг, шинжилгээ, оношилгоо,</li> <li>Томограф хийх гэх мэт.</li> </ul>
3.3	Сэтгэл зүйн үйлчилгээ /33.1.3/	1 хоногт	3500	<ul style="list-style-type: none"> <li>Ганцаарчилсан зөвлөгөө, сэтгэл засал</li> <li>Сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглах бичиг баримт.</li> </ul>
3.4	Нийгмийн халамжийн үйлчилгээ /33.1.4/	1 хоногт	3500	<ul style="list-style-type: none"> <li>Кейс файл бүрдүүлэх,</li> <li>Чадавхжуулах цогц үйлчилгээ,</li> <li>Ажлын байранд холбон зуучлах,</li> <li>Бие даан амьдрах ухааны сургалтууд.</li> </ul>
3.5	Эрх зүйн туслалцаа /33.1.6/	1 хоногт	3.500	<ul style="list-style-type: none"> <li>Нотлох баримт бүрдүүлэх, өргөдөл, нэхэмжлэл бичих, зөвлөгөө өгөх, хууль шүүхийн байгууллагад итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орох, шүүх хуралд бэлтгэх.</li> </ul>
<b>Дэд дүн</b>			<b>17500</b>	

Жич: Үйлчилгээний төрлийг ГБХТТХ-ийн 33 дугаар зүйлд тусгасанаар оруулав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
Сангийн сайдын хамтарсан  
2019 оны...дугаар сарын ....-ны өдрийн  
...дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ**

№	Зардлын ангилал	Үнийн дүн, мян.төг
1	Хангамж, бараа материалын зардал	10 400
2	Нормативт зардал /хоол 4277, эм хэрэгсэл 1500/	10966
3	Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний зардал	17 500
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>38896</b>

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
Сангийн сайдын хамтарсан  
2019 оны...дугаар сарын ....-ны өдрийн  
...дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ  
ХУВЬСАХ ЗАРДЛЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭР АВАХАД  
БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ**

<b>Д/д</b>	<b>Бүрдүүлэх бичиг баримт</b>	<b>Тэмдэглэл</b>
1	Үйлчилгээнд хамрагдахыг хүссэн насанд хүрсэн иргэний өргөдөл	
2	Иргэний үнэмлэх /16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ-ний хуулбар эсвэл цахим тодорхойлолт	
3	Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт	
4	Үйлчлүүлэгчийг баг хорооны хамтарсан багт холбон зуучилсан тухай мэдээлэл	
5	Нөхцөл байдлын үнэлгээний хуудас	
6	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдсан иргэний хувийн хэрэг	

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
Сангийн сайдын хамтарсан  
2019 оны...дугаар сарын ....-ны өдрийн  
...дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд  
хамрагдах иргэний хувийн хэргийн загвар

**ТҮР БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН  
ИРГЭНИЙ ХУВИЙН ХЭРЭГ**

..... Аймаг, дүүрэг  
..... Сум, хороо

Овог : ..... Нэр: .....

Төрсөн он сар өдөр: ..... нас: ..... хүйс: .....

Регистрийн дугаар: .....

Эхэлсэн он сар өдөр: .....

Дуусах он сар өдөр: .....

Хаяг:

1.....  
2.....

Хувийн хэрэг нээсэн: аймаг, дүүргийн ..... сум, хорооны

Нийгмийн ажилтан: гарын үсэг: /:...../

(Төрийн байгууллагын)

Нийгмийн ажилтан: гарын үсэг: /:...../

(Гэрээлэн гүйцэтгэсэн ТББ-ын Нийгмийн ажилтан)

Хянасан: Асуудал хариуцсан мэргэжилтэн: /:...../

Баталсан: Үйлчилгээний хэлтсийн дарга: /:...../

.. .сар.....өдөр



## ТАНИЛЦУУЛГА

### “Түр Хамгаалан Байрлуулах Үйлчилгээний Нэг Хүнд Ногдох Хувьсах Зардлыг Тооцох Журам”-Ын Төсөл Боловсруулсан Тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т заасан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох бөгөөд хувьсах зардлыг тооцох журмыг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцох журам”-ын төслийг боловсруулав.

Энэхүү журмын төслийг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилготой түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг тооцоход баримтлах болно.

Түүнчлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 10 дугаар зүйлийн 10.1.2, 12 дугаар зүйлийн 12.1.6, 12.2.3, 18 дугаар зүйлийн 18.1.3, 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.1.5-д тус тус заасны дагуу түр хамгаалах байрыг улс, орон нутгийн төсвөөр байгуулж, санхүүжүүлэхээр заасан байдаг. Иймээс түр хамгаалах байранд ажиллах ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, түүнд ногдох ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг төлөх зардлыг “түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээ”-нд оруулан тооцохгүй байхыг зүйтэй гэж үзлээ.

Уг журмын төсөлд тусгагдсан хувьсах зардлыг Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалын Зардлын эдийн засгийн ангилалыг үндэслэл болгосон.

Мөн хоолны зардлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-ээр тооцож, нэгж үнийг Нийслэлийн Статистикийн газрын 2019 оны 1 дүгээр сарын өргөн хэрэглээний барааны үнийн дүнгээр тооцлоо.

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын тооцоог дор дурдсан зардлын нарийвчилсан ангиллаар хийж хүргүүлэв.

Хянан үзэж хамтран батлах арга хэмжээ авна уу.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

## **ЗАРИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛБАР**

### **Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн хоол:**

Хоногт хэрэглэх мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн будааны жишиг хэмжээг Монгол хүний хоногийн дундаж хэрэглээг үндэслэв.

Хоногийн хүнсээр авах нийт илчлэгийн хэмжээг Дэлхийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, ДЭМБ, НҮБ-ын мэргэжлийн шинжээчдийн 2001/2002 оны зөвлөлгөөнөөр хэлэлцэн баталсан "Хүний илчлэгийн хэрэгцээ"-гээр тооцсон болно.

Зөвлөмж болгож буй хүнсний бүтээгдэхүүнээр авах илчлэг, уураг, тос, нүүрс усны хэмжээг тооцохдоо мах, махан бүтээгдэхүүнийг үхрийн мах, гурилыг улаан буудайн 1-р гурил, гурил, гурилан бүтээгдэхүүнийг улаан буудайн гурилан талх, сүүн бүтээгдэхүүнийг тараг, төрөл бүрийн будааг цагаан будаа, сахар, чихрийн зүйлийг элсэн чихэр, хүнсний ногоог лууван, жимс, жимсгэнийг алимаар төлөөлүүлэн авлаа.

### **Аюулгүй байдлын хамгаалалт:**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасны дагуу түр хамгаалах байрны аюулгүй байдлын хамгаалалтыг цагдаагийн байгууллага, эсхүл гэрээт харуул хамгаалалтын байгууллагаар гүйцэтгүүлнэ гэж заасан. Бодит байдал дээр, ялангуяа нийслэлд цагдаагийн байгууллага аюулгүй байдлыг хариуцах боломжгүй байдаг учир хамгаалах байранд дохиолол хамгааллын тусгай тоног төхөөрөмж суурилуулж, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг байнга хангаж ажиллана. Энэ тохиолдолд гэрээт ажлын төлбөр, дуудлагын төлбөр гэх мэт зардлууд гардаг тул үүнийг тооцоолж, хамгийн багаар тооцсон болно.

### **Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ:**

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчид бие махбодийн хувьд ихэвчлэн хүндэвтэр болон хүнд бэртэж гэмтсэн байдаг. Иймд яаралтай тусламжийн үйлчилгээтэй холбох, хүргэж өгөх болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээхийн тулд эмнэлэг, эрүүл мэндийн мэргэжлийн үйлчилгээ чухал байдаг.

Хамгаалах байраар үйлчлүүлж буй нийт үйлчлүүлэгчдийн 80% нь бичиг баримт болон эрүүл мэндийн дэвтэргүй эсвэл эрүүл мэндийн даатгалаа төлөөгүй байх тохиолдол их байна. Хамгаалах байранд байрлах хугацаанд нь эмнэлэгт хүүхэд хэвтэхэд дор хаяж сахиурын мөнгө 2000 төгрөг эмнэлэгт тушаах, шүүх эмнэлэгт хохирогчийг үзүүлэх зардалд бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол 5000 төгрөг, гэр бүлийн болон бусад зүйлээс болж гэмтэж бэртсэн бол 3000 төгрөг гэх мэт төлөх, гэмтлийн эмнэлэгт үзүүлж шарх боолгох, эрчимт эмчилгээ хийлгэх үед шаардлагатай тохиолдолд эм, тариа худалдан авдаг. Энэ нь гэмтлийн зэргээс шалтгаалан өөр өөр байдаг. Мөн томографикийн зураг авахуулахад бичиг баримт байхгүй бол 80000-150000 төгрөг төлөх, эрүүл мэндийн даатгалын дэвтрийг шинээр авах, бүтэн жилийн

хураамж 57.600 төгрөг хагас жилээр төлөхөд 28.800 төгрөг дэвтрийн мөнгө 400 төгрөг, эх хүүхдийн ягаан дэвтэр авахад 1600 төгрөг гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээнд ихээхэн зардал гардаг болно.

### **Сэтгэл зүйн үйлчилгээ:**

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчид учирсан сэтгэл зүйн хохиролыг сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага буюу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөр оношлуулах, хуулийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд дүгнэлт гаргуулах, сэтгэц заслын эмнэл зүйн үйлчилгээг хийлгүүлэх болон сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглагдах хэрэглэгдэхүүнд гарах зардал багтана.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйлчилгээ:

- Оношлогоо
- Дүгнэлт гаргах
- Сэтгэц заслын эмнэлзүйн эмчилгээ

Сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглагдах хэрэглэгдэхүүн:

- Зургийн сэтгэл засалд ашиглагдах материал
- Хөгжим болон хөдөлгөөний сэтгэл засалд ашиглагдах материал
- Бага насны хүүхдэд зориулсан тоглоомын сэтгэл засалд ашиглагдах материал
- Бүлгийн сэтгэл засалд хэрэглэгдэх зэрэг материалыг худалдан авах шаардлагатай байдаг.

### **Нийгмийн ажлын үйлчилгээ:**

Нийгмийн ажлын үйлчилгээ нь гэр бүлийн бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралд хэвийн оруулах, нөөц чадавхийг илрүүлэх, чадваржуулах замаар тэдэнд тохиолдож буй харилцаа, нийгэм, сэтгэлзүйн асуудлыг шийдэхэд туслалцаа үзүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Мөн үйлчлүүлэгчдийн боловсрол мэдлэгээ дээшлүүлэхэд дэмжин туслах, амьдрах ухааны мэдлэг, чадварыг олгох, өөрийн гэсэн гэр орон, ажлын байртай болоход нь туслах, бага насны хүүхдүүдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээ үзүүлэх гэх мэт үйлчилгээний хугацаа, үйлчлүүлэгчийн нөхцөл байдлаас шалтгаалж ихээхэн зардал гарах шаардлагатай болдог.

### **Эрх зүйн туслалцаа:**

Хамгаалах байраар үйлчлүүлж буй нийт үйлчлүүлэгчдийн 80-аас дээш хувь нь амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой, нөгөө талаас хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хувьд хараат байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын ихэнх хувь нь хуулийн байгууллагад хандан, хамгаалуулахад нь хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллээр хангах, туслалцаа үзүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Ихэнх хохирогчид нотлох баримт бүрдүүлэх- нотариат, гэмтлийн зураг угаалгах, өргөдөл



гомдол, нэхэмжлэл бичих, хууль шүүхийн байгууллагад итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орох, шүүх хуралд бэлтгэх, эрхзүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчид төлөх төлбөр зэрэг үйлчилгээнд зардал гардаг.

**Холбон зуучлах:**

Хамгаалах байранд байрлан аюулгүй байдлаа хамгаалуулж буй үйлчлүүлэгчдийг бусад нарийн мэргэжлийн үйлчилгээ болон нөөц боломжид холбож чадавхижуулах зайлшгүй шаардлага гардаг. Тухайлбал: дээрх үйлчилгээнээс гадна мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, дамжаанд хамруулах, иргэний бичиг баримтжуулах, хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж холбон зуучлах гэх мэт үйлчилгээг цогцоор үзүүлэх шаардлагатай байдаг. Энэ тохиолдол бүрт зардал гардаг.

ТӨСӨЛ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ  
ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ БА ТАЙЛБАР**

№	Зардлын нэр	Үнийн дүн	Тайлбар
<b>НЭГ. ХАНГАМЖ, БАРАА МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ</b>			
1	Бичиг хэрэг	1500	Насанд хүрсэн хохирогч, хүүхдийг ирэхээс эхлээд хувийн хэрэг нээж ажиллаж эхлэнэ. Хүүхдийн хувийн хэрэг / 15 маягт 40 нүүр бүхий /
2	Харилцаа, холбоо	1500	Хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлаар холбогдох байгууллага болох тухайн хорооны хамтарсан баг, сургуулийн нийгмийн ажилтан, шүүх цагдаагийн байгууллагын ажилтантай холбогдох байнгын холбоотой байх шаардлагатай байдаг.
3	Тээвэр шатахуун	3000	Шүүх эмнэлэг, эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлэг, хороо, халамж, асрамж, халамжийн төв зэрэг байгууллагууд руу хүргэх, аюулгүй байдлыг нь хангаж ажиллахад тусгай унаагаар үйлчлэх шаардлагатай байдаг. Нэг үйлчлүүлэгч эмэгтэй 1-3 хүүхдийн хамт хамгаалах байранд байрладаг тул гадуур ажиллаар гарах тохиолдолд 1-3 хүүхдийг нь хамт авч явах шаардлага гардаг.
4	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	4400	Хохирогч хүүхэд, эмэгтэйчүүд анх хамгаалах байранд байрлахад нь хэрэглэгдэх оо, сойз, гар нүүрийн алчуур, гарын саван шампунь, ариун цэврийн цаас, хүүхдийн пампарс, дамсаг, угаалгын нунтаг, хувцсыг солих, ариутгах, усанд оруулах, бөөсний шампунь, ариутгалын бодис гэх мэт маш олон төрлийн ариун цэврийн хэрэгсэлүүд шаардлагатай байдаг. Жишээлбэл, Хүүхдийн түр хамгаалах байранд үйлчлүүлж байгаа хүүхдэд хэд ч хоносон дараах ариун цэврийн хэрэгслийг хувьд нь гаргаж өгдөг. Үүнд: анх ирэхэд нь бүх хувцсыг солих, ариутгах, усанд оруулах, бөөсний шампунь, ариутгалын бодис гэх мэт зүйлсийг өгнө. Эрүүл мэнд, ариун цэврийн үйлчилгээ /бөөсний шампунь-29900 биеийн тос-5000, гар ариутгагч-5000, гар нүүрийн саван-1500,шүдний 00 - 6000 хэрэглэнэ, памперс - 800 ./

<b>ДЭД ДҮН</b>	<b>10400</b>	
<b>ХОЁР. НОРМАТИВ ЗАРДАЛ</b>		
5	Хоолны зардал	<p>Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж нормативыг жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг үндэслэн тогтоосон Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 тоот тушаалыг үндэслэв.</p> <p>Хоногийн хүнсээр авах нийт илчлэгийн хэмжээг Дэлхийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэсний байгууллагын мэргэжлийн шинжээчдийн 2001/2002 оны зөвлөлгөөнөөр хэлэлцэн баталсан "Хүний илчлэгийн хэрэгцээ"-гээр тооцсон болно.</p> <p>9496 Зөвлөмж болгож буй хүнсний бүтээгдэхүүнээр авах илчлэг, уураг, тос, нүүрс усны хэмжээг тооцохдоо мах, махан бүтээгдэхүүнийг үхрийн мах, гурилыг улаан буудайн 1-р гурил, гурил, гурилан бүтээгдэхүүнийг улаан буудайн гурилан талх, сүүн бүтээгдэхүүнийг тараг, төрөл бүрийн будааг цагаан будаа, сахар, чихрийн зүйлийг элсэн чихэр, хүнсний ногоог лууван, жимс, жимсгэнийг алимаар төлөөлүүлэн авсан.</p> <p>Өргөн хэрэглээний барааны үнэ болон ахуйн хэрэглээний барааны үнийг Нийслэлийн Статистикийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн үнийн мэдээллийг үндэслэн тооцлоо. Түр хамгаалах байраар үйлчлүүлж буй иргэнийг өдөрт 2 удаагийн хөнгөн цай уух бөгөөд нэг удаагийн цайны зардлыг 1000 төгрөгөөр тооцов.</p>

6	Эм бэлдмэл	1500	<p>Олон улсын хэмжээнд жил бүр 4-6 сая эмэгтэй 15 секунд тутамд зодуулж байдаг. Тэдний зөвхөн 7 хувь нь эмнэлгийн тусламж авдаг байна. Гэмтлийн шалтгааны ихэнхийг гэр бүлийн хүчирхийлэл эзэлдэг төдийгүй хамгийн их халдварт бус өвчнөөр өвдөх эрсдэл учруулж байна.</p> <p>Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 47 дугаар тогтоолоор батлагдсан хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах стандартын 8,1 зааснаар хамгаалах байрны үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсээр ирсэн. Түр хамгаалах байранд байрлаж буй үйлчлүүлэгчдийн 20-30% нь хүчирхийллээс болоод нөхөн үржихүйн эрүүл мэндийн хувьд өвчлөлтэй болсон байдаг. Удаан хугацаанд зодуулсан эмэгтэйчүүдийн хувьд сав доргих, улмаар хүүхэд төрүүлж чадахгүй байх, ураг зулбах дотуур цус алдах зэрэг тохиолдлууд гардаг.</p> <p>2017 оны байдлаар ХЭҮТ-ийн хамгаалах байранд үйлчлүүлсэн нийт 114 эмэгтэйчүүдийн 12 нь хамрын яс хугарсан, 5 чихний хэнгэрэг цоорсон, 18 нь нүүр болон их биеийн зөөлөн эдэд няцралт үүссэн, 3 нь гэмтлийн улмаас дотуур цас алдсан, 8 нь гар хугарсан, 108 нь зүрх өвдсөн, 89 нь бамбай булчирхайн гүн хордлогонд орсон байна.</p> <p>Мөн бага насны хүүхдүүдийн хувьд хоол тэжээлийн хүнд дутагдалтай, ханиад томуу хүрсэн, хатгаатай, татаж унадаг болсон байх, цагаан хорхой байх тохиолдол их гардаг. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдийн хувьд бэлгийн замаар дамжих халдварт өвчин туссан байх тохиолдлууд ихээхэн гарч байна.</p> <p>Иймд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг эрүүл мэндийн хэвийн байдалд нь эргэн оруулах, нөхөн сэргээхэд удаан хугацаагаар эмчлүүлэх, эм тарианы зардал их гардаг тул эрүүл мэндийн үйлчилгээний зардалыг 1500 төгрөг болгох шаардлагатай байна.</p>
---	------------	------	--

			Голчлон хэрэглэгддэг эмүүд: - Цагаан хорхой устгах эм - 4500 төгрөг, гэдэсний халдварт өвчнийг гэрийн нөхцөлд эмнэх сироп -8200 төгрөг, гэдэсний өвчин намдаах эм-2000 төгрөг, биеийн халуун бууруулах лаа - 1000, даралтны эм - 5000 зэрэг болно.
	<b>ДЭД ДҮН</b>	<b>10996</b>	
			<b>ГУРАВ.</b>
7	Эрүүл мэндийн үйлчилгээ	3500	<p>Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчид бие махбодийн хувьд ихэвчлэн хүндэвтэр болон хүнд бэртэж гэмтсэн байдаг. Иймд яаралтай тусламжтай холбох, хүргэж өгөх болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээхийн тулд эмнэлэг, эрүүл мэндийн мэргэжлийн үйлчилгээ чухал байдаг. Хүүхдийн хамгаалах байранд бие махьюдийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч голдуу ирдэг.</p> <p>Хамгаалах байраар үйлчлүүлж буй нийт үйлчлүүлэгчдийн 80% нь бичиг баримт болон эрүүл мэндийн дэвтэргүй эсвэл эрүүл мэндийн даатгалаа төлөөгүй байх тохиолдол их байдаг. Хамгаалах байранд байрлах хугацаанд нь эмнэлэгт хүүхэд хэвтэхэд дор хаяж сахиурын мөнгө 2000 төгрөг эмнэлэгт тушаах, шүүх эмнэлэгт хохирогчийг үзүүлэх зардалд бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол 5000 төгрөг, гэр бүлийн болон бусад зүйлээс болж гэмтэж бэртсэн бол 3000 төгрөг гэх мэт төлөх, гэмтлийн эмнэлэгт үзүүлж шарх боолгох, эрчимт эмчилгээ хийлгэх үед шаардлагатай тохиолдолд эм, тариа худалдан авдаг. Энэ нь гэмтлийн зэргээс шалтгаалан өөр өөр байдаг. Мөн томографикийн зураг авахуулахад бичиг баримт байхгүй бол 80000-150000 төгрөг төлөх, эрүүл мэндийн даатгалын дэвтрийг шинээр авах, бүтэн жилийн хураамж 57.600 төгрөг хагас жилээр төлөхөд 28.800 төгрөг дэвтрийн мөнгө 400 төгрөг, эх хүүхдийн ягаан дэвтэр авахад 1600 төгрөг гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээнд ихээхэн зардал гардаг болно.</p>

8	Нийгмийн ажил үйлчилгээ	3500	<p>Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, дүүрэг, хорооны хамтарсан баг, кейс файл нээх, төлөвлөх, кейс төлөвлөгөө гаргах, бичиг баримтжуулах, халамж, иргэний бүртгэл гэх мэт үйлчлүүлэгчийн асуудлаас шалтгаалан олон байгууллагуудтай холбогдож үйлчилгээ үзүүлдэг.</p> <p>Нийгмийн ажлын үйлчилгээ нь гэр бүлийн бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралд хэвийн оруулах, нөөц чадавхийг илрүүлэх, чадваржуулах замаар тэдэнд тохиолдож буй харилцаа, нийгэм, сэтгэлзүйн асуудлыг шийдэхэд туслалцаа үзүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Мөн үйлчлүүлэгчдийн боловсрол мэдлэгээ дээшлүүлэхэд дэмжин туслах, амьдрах ухааны мэдлэг, чадварыг олгох, өөрийн гэсэн гэр орон, ажлын байртай болоход нь туслах, бага насны хүүхдүүдийг гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээ үзүүлэх гэх мэт үйлчилгээний хугацаа, үйлчлүүлэгчийн нөхцөл байдлаас шалтгаалж ихээхэн зардал гарах шаардлагатай болдог.</p>
9	Сэтгэл зүйн үйлчилгээ	3500	<p>Хамгаалах байранд буй үйлчлүүлэгчдийн 70 гаруй хувь нь хүчирхийллийн улмаас 1-3 удаа амиа хорлох оролдлого хийсэн байдаг.. Энэхүү бүртгэл судалгаан дээр үндэслэн 2010 оноос эхлэн Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 47 дугаар тогтоолоор батлагдсан Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах стандартын 10.4-д зааснаар хамгаалах байранд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулж эхэлсэн. мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулж эхэлсэн.</p> <p>Түр хамгаалах байранд байрлаж буй гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод хүчирхийллийн улмаас өөртөө итгэх итгэлгүй, өөрийн уур бухимдалаа хүүхэддээ гаргадаг, сэтгэл зүйн хямралтай, сэтгэл зүйн хувьд тогтворгүй айдастай байдаг урт хугацааны сэтгэл заслын болон нөхөн сэргээх үйлчилгээг тогтмол хугацаанд тасралтгүй үзүүлэх шаардлагатай байдаг. Иймд “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ”-д сэтгэл зүй болон сэтгэл заслын үйлчилгээ чухал үйлчилгээнүүдийн нэг байдаг.</p>

			<p>Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчид учирсан сэтгэл зүйн хохирлыг сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага буюу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөр оношлуулах, хуулийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд дүгнэлт гаргуулах, сэтгэц заслын эмнэл зүйн үйлчилгээг хийлгүүлэх болон сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглагдах хэрэглэгдэхүүнд гарах зардал багтана.</p> <p>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйлчилгээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Оношлогоо</li> <li>-Дүгнэлт гаргах</li> <li>-Сэтгэц заслын эмнэлзүйн эмчилгээ</li> </ul> <p>Сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглагдах хэрэглэгдэхүүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Зургийн сэтгэл засалд ашиглагдах материал</li> <li>-Хөгжим болон хөдөлгөөний сэтгэл засалд ашиглагдах материал</li> <li>-Бага насны хүүхдэд зориулсан тоглоомын сэтгэл засалд ашиглагдах материал</li> <li>-Бүлгийн сэтгэл засалд хэрэглэгдэх зэрэг материалыг худалдан авах шаардлагатай байдаг.</li> </ul>
10	Хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ	3500	<p>Хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн зардал</p> <p>Хамгаалах байраар үйлчлүүлж буй нийт үйлчлүүлэгчдийн 70-аас дээш хувь нь амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой, нөгөө талаас хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хувьд хараат байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын ихэнх хувь нь хуулийн байгууллагад хандан, хамгаалуулахад нь хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллээр хангах, туслалцаа үзүүлэх зайлшгүй шаадлагатай байдаг. Ихэнх хохирогчид нотлох баримт бүрдүүлэх- нотариат, гэмтлийн зураг угаалгах, өргөдөл гомдол, нэхэмжлэл бичих, хууль шүүхийн байгууллагад итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орох, шүүх хуралд бэлтгэх, эрхзүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчид төлөх төлбөр зэрэг үйлчилгээнд зардал гардаг.</p>

11	Аюулгүй байдлын үйлчилгээ	3500	<p>Үйлчлүүлэгчдийн хувьд аюулын эрсдлийн түвшин өндөр байдгаас хичээл сургуульдаа явах, гадуур ажил хөөцөлдөхөд хүчирхийлэгчид баригдах, амь нас, эрүүл мэндээрээ хохирох тохиолдол байна. Мөн эдгээр үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хамгаалан ажиллах явцад хүчирхийлэгч нь ажилтнуудын аюулгүй байдалд заналхийлэх тохиолдол их байна. Ялангуяа эрүүл мэндийн байгууллагатай холбоотой үйлчилгээ болон нөхцөл байдлын үнэлгээ хийлгэх, хохирогчийн өмнөөс хүсэлт гарган итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчөөр оролцоход илүү их эрсдэл тохиолдож байна. Иймд үйлчлүүлэгчийн болон ажилчдын аюулгүй байдлыг хангах үйлчилгээ нэн шаардлагатай байдаг.</p> <p>Түүнчлэн Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 47 дугаар тогтоолоор батлагдсан хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах стандартын 11.2-д зааснаар Хохирогчийг хамгаалах байранд байрлуулах үеийн аюулгүй байдлыг бүрэн хангахаар зааж өгсөн байдаг. Иймээс “Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ”-д үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын зардал чухал байдаг.</p>
	<b>ДЭД ДҮН</b>	<b>17 500</b>	
	<b>1 ХҮНД / ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД / НООГДОХ НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>38896</b>

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**